

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон бусад олон улсын эрх бүхий байгууллагаас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, терроризм болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж зарлагдсан болон хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэрсийн жагсаалт (цаашид “жагсаалт” гэх)-ыг Санхүүгийн мэдээллийн алба (цаашид СМА гэх)-наас мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдэгдэх, холбогдох эрх бүхий хууль сахиулах байгууллагад шалгуулахаар шилжүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй, түргэн шуурхай авч хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

1.3.Санхүүгийн мэдээллийн алба энэ журмын 1.1-д заасан жагсаалтыг дор дурдсан байгууллагаас хүлээн авна.

1.3.1.Нэгдсэн Үндэсний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний тогтоол (цаашид “тогтоол” гэх);

1.3.2.Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 348 дугаар тогтоолоор баталсан “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-д заасан эрх бүхий байгууллага;

1.3.3.Олон улсын эрх бүхий байгууллага.

1.4.Энэ журмын 1.1-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан дараах этгээд хамаарна. Үүнд:

1.4.1.Банк;

1.4.2.Банк бус санхүүгийн байгууллага;

1.4.3. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

1.4.4.хөрөнгө оруулалтын сан;

- 1.1.5.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- 1.1.6.хадгаламж, зээлийн хоршоо;
- 1.1.7.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- 1.1.8.нотариатч.

ХОЁР. ЖАГСААЛТЫГ МЭДЭЭЛЭХ

2.1.СМА нь жагсаалтад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг энэ журмын 1.3-т заасан эх сурвалжаас тэдгээрийн албан ёсны цахим хуудас, цахим шуудан, албан бичигт үндэслэн тогтмол шинэчлэн, өөрийн цахим хуудаст байршуулна.

2.2.СМА нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1-д заасны дагуу жагсаалтыг банкнуудад албан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ журмын 1.4-т заасан банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид СЗХ гэх) өөрийн цахим хуудаст мэдээллийг байршуулан мэдэгдэнэ..

ГУРАВ. МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДИЙН АВАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Энэ журмын 1.4-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагч, хүлээн авагч, шилжүүлэгч болон зуучлагчийн мэдээллийг уг жагсаалттай тулган шалгадаг дотоод тогтолцоог бий болгоно. Үүнд дараах арга хэмжээ хамаарна.

3.1.1.Байгууллагын дотоод дүрэм, журамд санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагч, хүлээн авагч, шилжүүлэгч болон зуучлагчийн мэдээллийг уг жагсаалттай тулган шалгах талаар тусгах;

3.1.2.Данс эзэмшигч, харилцагч, шилжүүлэгч, хүлээн авагч, зуучлагчдын дунд жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд байгаа эсэхийг тогтоох, харилцагчийг таньж мэдэх, өндөр эрсдэлтэй харилцагчийг тодорхойлох, өндөр эрсдэлтэй харилцагчийн талаар авах арга хэмжээний талаар холбогдох ажилтнуудыг сургах;

3.1.3.Байгууллагын холбогдох ажилтнуудыг шаардлагатай мэдээллийн технологийн хэрэгслээр хангах;

3.1.4.Данс эзэмшигч, харилцагч, шилжүүлэгч, хүлээн авагч, зуучлагчид, тэдгээрийн гүйлгээний талаарх мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд найдвартай хадгалж, мэдээллийн сан үүсгэх.

3.2.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь СМА-наас жагсаалтад өөрчлөлт орсон мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1.Өөрийн данс эзэмшигч, харилцагчдын дунд уг жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд байгаа эсэхийг түргэн шуурхай, үнэн зөвөөр тогтоох;

3.2.2.Жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд санхүүгийн үйлчилгээ хүлээн авагч, шилжүүлэгч эсхүл зуучлагч тал болж байгаа эсэхийг тогтоох;

3.2.3.Хувь хүн, хуулийн этгээдийн нэр жагсаалтад байгаа нэртэй тохирсон тохиолдолд дансыг царцаан, хийгдэх гэж байгаа гүйлгээг түдгэлзүүлж, тухайн гүйлгээ, данс эзэмшигч болон холбогдох гүйлгээнд оролцогч талуудын тухай мэдээллийг ажлын 8 цагийн дотор СМА-нд албан бичгээр болон Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдэгдэх;

3.2.4. Банк санхүүгийн байгууллага нь энэхүү журмын 3.2.3-т заасны дагуу түдгэлзүүлсэн гүйлгээ нь гадаад шилжүүлэг байсан тохиолдолд тухайн гүйлгээтэй холбоотой дараах СВИФТ баримтуудыг хавсаргаж СМА-нд ирүүлнэ. Үүнд:

- а.гадаадын банканд гүйлгээг шилжүүлсэн баримт;
- б.гадаадын банканд гүйлгээг түдгэлзүүлэхийг хүсэж илгээсэн лавлагаа;
- в.гадаадын банкнаас ирсэн хариу.

3.3.Банк санхүүгийн байгууллага гүйлгээг түдгэлзүүлэх гэж байгаа талаар тухайн харилцагч, гүйлгээнд оролцогч талд мэдэгдэхгүй бөгөөд тэдэнд ямар нэгэн хэлбэрээр мэдэгдэхийг хориглоно.

3.4.СМА эсхүл эрх бүхий төрийн байгууллагаас банк санхүүгийн байгууллагад түдгэлзүүлсэн гүйлгээ, данстай холбогдуулж тодорхой арга хэмжээ аваагүй, албан ёсны заавар, шийдвэр өгөөгүй бол 72 цагаас илүү хугацаагаар тухайн данс, гүйлгээг түдгэлзүүлэхгүй.

ДӨРӨВ. САНХҮҮ МЭДЭЭЛЛИЙН АЛБАНААС АВАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1.СМА нь жагсаалтад байгаа нэртэй тохирсон хувь хүн, хуулийн этгээдийн тухай мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдээс хүлээн авмагц дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.1.1.Албан ёсны жагсаалттай дахин тулган шалгаж тухайн хувь хүн, хуулийн этгээдийн нэр нь үнэн зөв тохирч байгаа эсэхийг нягтлан шалгах;

4.1.2.Дотоод, гадаадын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээллийг цуглуулж тухайн хувь хүн, хуулийн этгээд жагсаалтад байгаа байгууллага, этгээд мөн эсэхийг дахин лавлаж тодруулах;

4.1.3.Хувь хүн, хуулийн этгээдийн нэр жагсаалтад байгаа нэртэй тохирч байвал СМА-ны дарга түдгэлзүүлэх шийдвэрийг санхүүгийн байгууллагад нэн даруй албан бичгээр хүргүүлнэ. Ингэхдээ гүйлгээ түдгэлзүүлэх хугацааг санхүүгийн байгууллагын арга хэмжээ авч эхэлсэн хугацаагаар тооцно;

4.1.4.СМА-ны дарга тухайн хувь хүн, хуулийн этгээдийн тухай мэдээллийг гүйлгээ түдгэлзүүлэх, данс царцаах шийдвэрийн хуулбарын хамт холбогдох хууль сахиулах байгууллагад мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл хүлээж авснаас 24 цагийн дотор албан бичгээр мэдэгдэнэ;

4.1.5.СМА жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр давхардсан, ижил төстэй нэртэй, буруу тохирсон, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэрийг цуцалж энэ тухай санхүүгийн байгууллагад нэн даруй албан бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1.Нэр давхардсан буюу жагсаалтад орсон нэртэй адилхан нэртэй иргэн, хуулийн этгээдийн гүйлгээг түдгэлзүүлж, данс царцаасан тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 12.2 болон 12.3 дугаар зүйлийг баримтална.

5.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____